

ДУНДГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2026 оны 06-р сарын 02 өдөр

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
					Эхний хагас жил	Жилийн эцэс		
ЗОРИЛГО.УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ. /“Алсын хараа-2050” зорилт 5.3, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.2.3.1, 4.3.1.5, 4.3.3.6, Улсын бүртгэлийн байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө//								
1	Зорилт 1 Дэвшилтэд технологид суурилсан төрийн цахим үйлчилгээний байгууллага байна. Техник, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлнэ							
1.1.	Иргэний улсын бүртгэлийг хууль тогтоомж, холбогдох журмын дагуу бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх	-	бүртгэлийн үйлчилгээ авсан хувь	100	100		2026 оны тайлант хугацаанд 5028 иргэнд иргэний улсын бүртгэлийн үйлчилгээг хүргэлээ. Тус аймгийн Луус сумын улсын бүртгэгч эхийн чөлөөтэй, Дэрэн, Гурвансайхан, Өлзийт сумд улсын бүртгэгчгүй байгаа бөгөөд улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд хэвийн тасралтгүй хүргэх зорилгоор хэлтсийн улсын бүртгэгчид харъяалал харгалздаг бүртгэлийн эрхийг нэмж бүртгэлийн үйлчилгээг хэвийн явуулахын зэрэгцээ тухайн сумдад зохион байгуулагдсан малчдын өдөрлөг, олон нийтийг хамарсан үйл ажиллагааны үед зөөврийн төхөөрөмжөөр бүртгэлийн үйлчилгээг хүргэн ажиллаж байна. Тайлант хугацаанд төрөлтийн бүртгэлд 246, гэрлэлтийн бүртгэл 34, гэрлэлт дуусгавар болсны бүртгэл 13, үрчлэлт 5, эцэг тогтоолтын бүртгэл 21 , ОНӨ бүртгэл 9, нас барсны бүртгэлд 114, шилжилт хөдөлгөөний бүртгэлд 416, иргэний үнэмлэхийн бүртгэлд 735., гадаад паспортын бүртгэлд 659, нэмэлт өөрчлөлтийн бүртгэлд 669 нийт 2921 бүртгэл хөтлөн иргэний бүртгэлийн санд мэдээллийг баталгаажуулсан байна.	100
1.2	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг хууль	-	бүртгэлийн үйлчилгээ авсан хувь	100	100		2025.12.26-2026.05.25-ны өдрийн байдлаар Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн нийт 1305 мэдүүлэг хүлээн авч бүртгэсэн байна. Үүнд: төрөөс хувьчилсан	100

	тогтоомж, журмын дагуу бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх					газрын анхны бүртгэл 146, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн анхны бүртгэл 199, шинээр баригдсан орон сууцны анхны бүртгэл 47, худалдах худалдан авах гэрээ 199, бэлэглэх гэрээ 47, өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх 21, шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх 3, бусад эрх шилжүүлэх бүртгэл 6, барьцааны гэрээний бүртгэл 398, барьцааны гэрээ дуусгавар болгох 279, түрээсийн гэрээ бүртгэх 2, үрэгдүүлсэн, гэмтээсэн гэрчилгээ дахин олгох 17, эд хөрөнгийн хаяг өөрчлөгдөх 20, эд хөрөнгийн зориулалт өөрчлөгдөх 5, эд хөрөнгийн хэмжээ үнэ гүйцэтгэл өөрчлөгдөх 20, лавлагаа хуулбар 12, хувийн хэрэг хаах 7 бүртгэл тус тус бүртгэсэн байна. Үйлчилгээний хураамж 19.0 сая.төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 1.3 сая.төгрөг, ҮХЭХҮЭ-ээ худалдсанаас оруулсан татварын орлого 88.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна	
1.3	Хуулийн этгээдийн бүртгэлийг хууль тогтоомж, журмын дагуу бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх	-	бүртгэлийн үйлчилгээ авсан хувь	100	100	1.Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан нэмэлт өөрчлөлт оруулсан: ххк 37, хоршоо 6, ХЗХ 2, Улсын төсөв үйлдвэрийн газар 4, төрийн байгууллага 4, ТББ 6, Боловсрол соёлын сургалтын байгууллага 2, ОНАААТҮГ-1,нийт 62, Шинээр 36 хуулийн этгээд байгуулан Үүнээс: ххк 23, хоршоо 2,Төрийн бус байгууллага 4, нөхөрлөл 6, ҮЭБ-1 бүртгэгдсэн. Дахин гэрчилгээ олгосон 11, 2шилжилт хөдөлгөөн хийсэн 2,Салбарын гэрчилгээ олгосон 3 нийт 114 бүртгэл хийж архивд 2215 хувийн хэрэг байршиж байна. 2.“Тамга тэмдэг баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих лавлагаа олгох журам”-д зааснаар Хяналтын дугаар олгосон шинээр 38, дахин олгосон 11, хураан авсан 14 тамга, тэмдэг архивд шилжүүлсэн. 3.Иргэн, хуулийн этгээдэд лавлагаа олгосон 18, хуулбар олгосон 5 бүртгэл байна. 4.Хуулийн этгээдийн бүртгэлээс орон нутгийн орлого 4568000 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн 5.Хуулийн этгээдийн оноосон нэрийг e-business.mn хүлээн авч татгалзсан 552, зөвшөөрсөн 72, баталсан 10 , цуцалсан 73 нийт 726 оноосон нэрийн бүртгэлийг баталгаажуулсан.	100

1.4.	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим системд “Г” дугаарт бүртгэгдсэн газар эзэмших, ашиглах эрх нь дундын мэдээллийн сангаар дамжуулан давхар бүртгэгдэж эрхийн улсын бүртгэлийн “Э”, “А” дугаар авсан хувийн хэргүүдийг судлан төлөвлөгөө гаргаж, хууль, журмын дагуу эрхийн улсын бүртгэлийг хаах		Төлөвлөгөөний хувь	100	100	Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2026.05.15-ны өдрийн А/107 тушаалын дагуу аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын баримтад нэгдсэн тооллого явуулах ажлын хэсгийг хэлтсийн даргын 2026.05.19-ны өдрийн А/05 тушаалаар байгуулсан ба ажлын хэсэгт хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн бүртгэгч, архивч, сумдын бүртгэгч нар ажиллан хуваарийн дагуу тооллогын ажлын хийж гүйцэтгэж байна .	30
1.5	Төрийн болон хууль хяналтын байгууллагатай цахимаар мэдээлэл, лавлагаа, хуулбар олгох.		Лавлагаа, мэдээллийн тоо	300	310	Тайлант хугацаанд нийт 2014 лавлагаа олгосон бөгөөд хууль хяналтын байгууллагад тайлант хугацаанд хугацаатай, хариутай 22 албан бичгийн хүрээнд 91 лавлагаа хэвлэж олголоо. Үүнээс шүүх 51, цагдаагийн байгууллага 22, прокурор 18 лавлагаа авсан байна. Төрлөөр нь авч үзвэл иргэний байнгын оршин суугаа хаягийн лавлагаа 48, цахим үнэмлэхийн лавлагаа 31 олголоо. Төрийн болон хууль хяналтын байгууллагад эд хөрөнгөтэй эсэх лавлагаа 5 , үл хөдлөх эд хөрөнгийн дэлгэрэнгүй лавлагаа 9 нийт 14 лавлагааг гарган албан бичгээр хариуг хүргүүлсэн. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас ирүүлсэн үл хөдлөх эд хөрөнгийн захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлэх тогтоолын дагуу 6, үл хөдлөх эд хөрөнгийн захиран зарцуулах эрхийг сэргээх 22, хөрөнгө	100

						битүүмжлэх тухай тогтоолын дагуу 2, аймгийн татварын газраас үл хөдлөх эд хөрөнгийн захиран зарцуулах эрхийг сэргээх, эрх шилжүүлэх албан бичгийн дагуу 2, Хяналтын улсын байцаагчийн дүгнэлт 2 зэрэг нийт 75 бүртгэлийг эд хөрөнгийн мэдээллийн цахим системийн “албан бичиг” цэсэнд бүртгэн хариуг /лавлагааг, гэрчилгээний хуулбарын хамт/ хүргүүлсэн.	
1.6	Байгууллагын архивын баримтыг цахимжуулах.		Цахимжуулсан баримтын тоо	8 боть	8	Ирсэн-408, явсан бичиг-220, өргөдөл гомдол-16, тушаал-13 зэргийг цахимжуулсан ба жилийн эцсээр байнга хадгалах хадгаламжийн нэгж үүсгэн цахимжуулна.	-
1.7	Бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналтыг сайжруулах.		Хяналт тавьсан бүртгэлийн тоо	2111	2200	Улсын бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2026 оны эхний 5 сарын байдлаар нийт 5 удаагийн төлөвлөгөөт хяналт шалгалтыг хуваарийн дагуу зохион байгуулж ажиллав. Сар бүр дунджаар нэг төлөвлөгөөт шалгалт хийгдсэн бөгөөд тайлант хугацаанд гүйцэтгэлийн болон гэнэтийн шалгалт хийгдээгүй байна. Хяналт тавьсан бүртгэлийн статистик үзүүлэлт Хяналт шалгалтын явцад нийт 1,687 бүртгэлд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав. Үүнийг бүртгэлийн төрлөөр ангилбал: · Эд хөрөнгийн эрхийн бүртгэл: Нийт 906 бүртгэлд хяналт тавьсан нь нийт шалгалтын хамгийн их буюу 53.7 хувийг эзэлж байна. · Иргэний улсын бүртгэл: Нийт 686 бүртгэлд хяналт тавьж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгав. · Хуулийн этгээдийн улсын бүртгэл: Нийт 95 бүртгэлд хяналт тавьж ажилласан байна. Хяналт шалгалтын үр дүнг үндэслэн улсын байцаагчийн зүгээс нийт 22 дүгнэлт гаргаж, бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр арга зүйн зөвлөмж өгсөн. Үүнээс: · Иргэний бүртгэлийн чиглэлээр 10 дүгнэлт; · Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 10 дүгнэлт;	100

						Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 2 дүгнэлтийг тус тус үйлдсэн байна. Тайлант хугацаанд улсын байцаагчийн зүгээс бүртгэлийг түдгэлзүүлсэн, хориг тавьсан эсвэл цуцалсан тохиолдол бүртгэгдээгүй бөгөөд бүртгэлийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. УБЕГ-ын даргын 2026 оны 04-р сарын 23-ний өдрийн А/88 дугаар тушаалын хавсралт "ИРГЭНДЭЭ ЭЭЛТЭЙ БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АЯН"-ны удирдамжийн хүрээнд: 3.3 Үйлчилгээний танхимд QR код байрлуулж, иргэнд тулгарсан хүндрэл болон үйлчилгээ үзүүлсэн албан хаагчийн, үйлчилгээний чанарын талаар сэтгэл ханамжийн судалгаа авч мэдээ мэдээллээр бүрэн хангагдсан эсэхийг үнэлж, дүгнэн холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.	
1.8	Зөрчлийн бүртгэл мэдээлийн цахим санг ашиглах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах		Зөрчил буурсан байх, Зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулсан тоо	2	3	Дундговь аймгийн хэмжээнд 2026 онд 16,25,45 нас хүрэх иргэдэд зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хуульд заасан хугацаанд улсын бүртгэлд бүртгүүлээгүй тохиолдолд гарч болох эрсдэл, торгууль шийтгэлийн талаар цахим контент хэлбэрээр сурталчилгаа хийх, албан байгууллага, сургуулиудад мэдээлэл хийх гэх мэт олон ажлыг зохион байгуулж ажиллалаа. Тайлант хугацаанд нийт 21 зөрчил хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэснээс зөрчлийн тухай хуулийн 15.24.1-д заасан зөрчил үйлдсэн-20, 15.24.2-д заасан зөрчил үйлдсэн -1 байна.. Сумдын улсын бүртгэгч нар тухайн онд 16 насанд хүрэх, хугацаа сунгах иргэдийн нэрсийг багийн дарга нараас гаргуулан авч, нэг бүрчлэн утсаар холбогдож зөвлөгөө, мэдээлэл, иргэний үнэмлэхийн хугацаа сунгах сануулга өгч ажилладаг бөгөөд Дундговь аймгийн төвийн сумаас бусад сумдаас иргэний үнэмлэхийн хугацааны торгууль төлөхөөр ирэх иргэдийн тоо буурсан бөгөөд иргэдэд чирэгдэлгүй, цаашдаад бусад эрсдэлээс урьдчилан сэргийлж байгаа давуу талтай юм. Мөн түүнчлэн 15 сумдын улсын бүртгэгч нараас 2026 онд 16, 25, 45 насанд хүрч иргэний үнэмлэх захиалах	100

						иргэдийн судалгааг авч, иргэн бүртэй утсаар, болон биеэр холбогдож төрсөн өдрөөс хойш 30 хоногийн дотор иргэний үнэмлэхийн сунгалтаа хийлгэх ёстойг сануулж ажиллах үүргийг сумдын бүртгэгч нарт өгснөөр төвийн сум буюу Сайнцагаан сумаас бусад 14 сумдаас хууль, журам зөрчсөн зөрчилтэй бүртгэл бүртгэгдэхгүй болсон. Уг ажлыг хийснээр зөрчлийн тухай хуулиар торгуулах иргэдийн тоо буурч байгаа давуу талтай юм.	
1.9	Иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмж шуурхай байдлыг нэмэгдүүлэх зорилгоор архивын цаасан маягтыг мэдээллийн санд оруулж иргэдийг цахимаар мэдээлэл авах боломжийг бүрдүүлэх		Иргэд цахимаар үйлчилгээ авах боломж бүрдэнэ.	500	1500	Тайлант хугацаанд нэмэлт өөрчлөлтийн бүртгэлээр мэдээллийн санд төрөлт, овог нэр өөрчлөлт, эцэг тогтоолт, үндсэн мэдээллийн санд гэрлэлтийн төлөв буруутай орсон зэрэг 441 бүртгэлийг хяналтын улсын байцаагчийн 6839 болон 4865 тоот дүгнэлт, иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд архивын эх нотлох баримт, холбогдох журам, улсын ерөнхий байцаагчийн 2026 оны 05 сарын 19-ний өдрийн 1989 тоот дүгнэлтийг дүгнэлтүүдийг үндэслэн засвар оруулсан. Мөн журнал бүртгэл, мэдээллийн санд эх нотлох баримт нь байгаа боловч мэдээлэл нь шивэгдэж ороогүй 228 бүртгэлийг нөхөн бүртгэлийг бүр орууллаа. Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, цахим шилжилт, мэдээллийн санг цэгцлэх ажлын хүрээнд Иргэний улсын бүртгэлийн газраас 2026 оны 03 сарын 24-нд дотоод сүлжээгээр ирүүлсэн үүрэг даалгаврын дагуу нас барсны бүртгэлийн цахим санд овог нэр нь дутуу бүртгэгдсэн 37 иргэний мэдээллийн зөрчлийг арилгах, нэмэлт өөрчлөлтийн бүртгэлээр алдааг засаж, гүйцэтгэлийг ханган ажиллав.	100
1.10	Иргэний бүртгэлийн архивын баримтыг хадгалалт, хүртээмж, аюулгүй байдлын шаардлагад нийцүүлэн үе шаттай цахимжуулах		Цахимжуулсан баримтын тоо	2000	2100	Тайлант хугацааны ИГББүртгэлийн нийт 422 бүртгэлийн иргэний улсын бүртгэлийн маягт, биеийн давхцахгүй өгөгдлийн 588 ИУБ-31 маягт, шилжилт хөдөлгөөний бүртгэлийн 210 нийт 1220 маягтыг архивт хүлээлгэн өглөө. ИГББүртгэл, шилжилт хөдөлгөөний нийт 1120 маягтын 4896 хуудас эх нотлох баримтыг цахимжууллаа. Улсын бүртгэлийн нэгдсэн архивын даргын 2024 оны 6 сарын 25-ны өдрийн 9/8570 тоот албан бичгээр иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийг цахимжуулах тухай үүрэг даалгаврын хүрээнд 780	100

	ажлыг зохион байгуулах.						хувийн хэргийг цахимжууллаа.	
ЗОРИЛТ 2.ОРЧИН ҮЕИЙН ШИНЭ ТЕХНИК, ТЕХНОЛОГИ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙГ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛЖ, ТӨРӨӨС ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮЗҮҮЛЭХ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ, ШУУРХАЙ БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛНЭ.								
2.1.	Улсын бүртгэлийн үйлчилгээг хөдөлгөөнт хэлбэрээр үзүүлэх /4 жи төхөөрөмж ашиглах/		Улсын бүртгэлийн хөдөлгөөнт үйлчилгээний тоо	5	10		Төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, тэгш хүртээмжтэй хүргэх зорилгоор улсын бүртгэлийн үйлчилгээг биечлэн авах боломжгүй иргэдэд бүртгэлийн зөөврийн төхөөрөмж ашиглан төрийн үйлчилгээг газар дээр нь хүргэн ажиллаж байна. Тайлант хугацаанд Сайнцагаан сумын 7 дугаар багийн 1 өндөр настанд гадаад паспорт захиалга, 5 дугаар багийн 16 настай 1 иргэн шинээр, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар ял эдэлж байгаа 1 иргэнийг 45 насны сунгалтаар биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд тус тус бүртгэж үйлчилгээг шуурхай хүргэж ажилласан. Мөн Сайхановоо, Дэлгэрцогт, Цагаандэлгэр сумдын улсын бүртгэгчид бүртгэлийн зөөврийн төхөөрөмж ашиглан төрөлтийн бүртгэл, эцэг тогтоолтын бүртгэл, тоон гарын үсэг олголт, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл зэрэг нийт 33 иргэнд бүртгэлийн үйлчилгээг хүргэсэн байна. “Иргэндээ ээлтэй бүртгэлийн үйлчилгээ”-ний аян хүрээнд 2026 оны 05 сарын 11, 14-ны өдөр Гурвансайхан, Дэлгэрцогт сумдад зохион байгуулагдсан малчны өдөрлөгт оролцож бүртгэлийн үйлчилгээг зөөврийн төхөөрөмжөөр газар дээр нь хүргэж ажиллалаа. Өдөрлөгийн үеэр гадаад паспорт, иргэний үнэмлэх, тоон гарын үсэг олголтыг 35 иргэн, төрсний болон гэрлэсний нөхөн бүртгэл, засвар өөрчлөлтийг 28 иргэн, тараах материал, зөвлөмж мэдээллээр 58 иргэн, Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр нийт 12 иргэнд бүртгэлийн үйлчилгээ үзүүлж, 23 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч нийт 156 иргэнд үйлчилгээ үзүүллээ.	100
2.2.	Улсын бүртгэлийн үйлчилгээг иргэд цахим машин	-	Аймгийн хэмжээнд улсын бүртгэлийн үйлчилгээний	5	6		Тус аймгийн Хулд, Говь-Угтаал, Баянжаргалан Сайнцагаан, Өлзийт зэрэг 5 суманд бүртгэлийн үйлчилгээний киоск машин ажиллаж байна.	100

	(Киоск)-оор авах мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх		цахим машин /Киоск/-ны хэрэглээг нэмэгдүүлэх, сурталчилсан тоо			Бүртгэлийн үйлчилгээний киоск машинаар тайлант хугацаанд хаягийн лавлагаа 83, цахим иргэний үнэмлэхийн лавлагаа 67 бусад лавлагаа 8 нийт 83 лавлагаа авсан байна. Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн мөнгөн төлбөрийн үйлчилгээг /ГЭРЭГЭ/ цахимаар 1105 иргэнд заавар зөвлөмж өгч үйлчилгээний хураамжаа төлүүллээ. E-Mongolia-аар хаясан цахим үнэмлэх , бусад төрлийн лавлагааг авах зөвлөгөөг өгч 86 – иргэн ашигласан байна. Цахим машин /киоск/-оор авах мэдлэг, мэдээллийг иргэдэд нээлттэй ил тод улирал бүр тогтмол байршуулан, мэдээллийн ил тод байдлын самбар, вэб сайт, сошиал хуудсанд байршуулсан. Иргэд энэхүү төхөөрөмжийг ашигласнаар төрийн үйлчилгээг аливаа дараалал, хүлээлтгүйгээр сумдын киоск машинаас үйлчилгээ авах боломж бүрдсэн.	
2.3	Иргэдийн Санал өргөдөл Гомдлын шийдвэрлэлтийг хууль тогтоомж, журмын дагуу барагдуулах	-	Санал өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хувь	100	100	2026 оны 05 дүгээр сарын 31-ны байдлаар 16 өргөдөл хүсэлт ирснээс өргөдөл гомдлын барагдуулалт 100%	100
			Шийдвэрлэлтийн хугацаа	9	7	Тус оны эхний хагас жилийн байдлаар сар бүр буюу 5 удаа өргөдөл гомдлын мэдээг хугацаанд нь хүргүүлсэн байна. Шийдвэрлэлтийн дундаж 5 хоног байна.	100
ЗОРИЛТ 3.УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН СҮЛЖЭЭ, СҮЛЖЭЭНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАНА.							
3.1.	Улсын бүртгэлийн байгууллагын кибер аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, нэгдсэн сүлжээ, программ хангамж, системийн аюулгүй байдлыг		Кибер аюулгүй байдлын эрсдэлийн төлөвлөгөөний хувь	100	100	Сүлжээгээр зөвшөөрөлгүй гадны хандалтыг галт ханын түвшинд хязгаарласан бөгөөд дотоод сүлжээнд байршуулсан файл, хавтаснуудыг төв сервер дээр хадгалж, системээр хянаж ажилладаг. Цахим мэдээллийн санг хард диск дээр давхар хадгалах замаар нөөцлөлтийг хийн ажиллаж байна. Тусгай зориулалтын архивын программ хангамж ашигладаггүй бөгөөд баримтын удирдлагыг гар аргаар зохион байгуулж, нөөц мэдээлэлд гараар хандан ажиллаж байна тохируулсан системээр хангадаг. Кибер аюулгүй байдал, мэдээллийн хамгаалалтын нэгдсэн сүлжээ, программ хангамж, системийн	100

	хангаж, эрсдэлийг бууруулах.						байгууллагын аюулгүй байдлын бодлого, журмын дагуу албан хаагчдад УБЕГ-ын Кибер аюулгүй байдлын хэлтэс сургалт зохион байгуулсан. Хэлтсийн албан хаагчдын ашиглах программ хангамжийг суулган, цахим мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангаж эрсдэлийг бууруулан ажиллаж байна.	
3.2.	Архивын баримтын хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулж, нууцлалыг хамгаалах	Бусад эх үүсвэр	Архивын өрөөнд /wifi/-тай камер шинэчлэн байршуулах	0	1		Архивын баримтын хадгалалт хамгаалалт, нөхцөлийг сайжруулж, нууцлалын аюулгүй байдлыг ханган архивын өрөөнд switch болон /wifi/-тай камер шинэчлэн байршууллаа.	100
3.3.	Улсын бүртгэлийн байгууллагын компьютер, түүний дагалдах техник тоног төхөөрөмжийг үе шаттайгаар шинэчлэн, сайжруулах		Техник, тоног төхөөрөмжийн шинэчилсэн тоо	2	2		Улсын бүртгэлийн ерөнхий газраас шинэ зөөврийн компьютер 4ш, сканнер 1ш, принтер 2ш, суурин компьютер 3ш, А, В media converter 2ш, киоск дөт машины процессор шийдүүлсэн. ОНСанхүүжилтээр Өндөршил сум ЗДТГ-аас 1ш медиа конвертор, Дэлгэрхангай сумын ЗДТГ-аас салаалагч шийдүүлэн шаардлагатай төхөөрөмжүүдийг үе шаттайгаар шинэчлэн сайжруулалт хийлээ.	100
ЗОРИЛТ 4.ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭН, БУСАД БАЙГУУЛЛАГЫН ТУРШЛАГААС БАЙГУУЛЛАГЫН ОНЦЛОГТ ТОХИРУУЛАН ХЭРЭГЖҮҮЛНЭ								
4.1.	Аймгийн ИТХурал, Засаг дарга, ЗДТГазартай хамтран ажиллах	Тухай бүр урсгал зардал, хөрөнгө бусад эх үүсвэрээр	Аймгийн ИТХ, ЗДТГазартай хамтран ажилласан арга хэмжээний тоо	3	4		Аймгийн Засаг даргатай 2026 онд хамтран ажиллах гэрээ байгуулж 1,2-р улиралд дүгнүүлэн орон нутгийн нэмэгдэл үндсэн цалингийн 60 хувийн нэмэгдлийг эхний 2 улиралд авсан байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Тэмээн дээрээс наран ойрхон” Өвлийн их наадам 1-р сарын 24, 25-нд Дундговь аймгийн Мандалговь хотноо зохион байгуулагдаж тус хэлтэс ерөнхийлөгчийн тамгын газрын албан хаагчдын гэр дааж авч 2 өдрийн турш зохион байгуулалтад хамтран ажилласан. Аймгийн ИТХурал, Засаг дарга, ЗДТГ-тай хамтран ажиллах гэрээний дагуу Билгийн тооллын XVII жарны	100

						“Сүрээр дарагч” хэмээх гал морин жилийн сар шинийн баярыг тохиолдуулан зохион байгуулсан “Нээлттэй Дундговь-2026” нэгдсэн арга хэмжээ 2026 оны 03-р сарын 05-ны өдөр Улаанбаатар хотын Монгол бөхийн өргөөнд болж өндөрлөлөө. Тус арга хэмжээг зохион байгуулах комисст аймгийн бүх хэлтэс агентлагуудын албан хаагчид оролцсоноос УБХ-ээс хяналтын улсын байцаагч оролцсон. Аймгийн Засаг даргатай 2026 онд хамтран ажиллах гэрээ байгуулж 1,2-р улиралд дүгнүүлэн орон нутгийн нэмэгдэл үндсэн цалингийн 60 хувтын нэмэгдлийг эхний 2 улиралд авсан байна. 2026 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 1-2/3305 тоот албан бичиг, Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон Аймгийн засаг даргын тамгын газраас ирүүлсэн удирдамж, хөтөлбөрийн дагуу тус хэлтэс “Про боно” хууль зүйн туслалцаа үзүүлэх өдөрлөгт оролцов. Тус өдөрлөг аймгийн Чагдаржавын талбайд зохион байгуулагдсан бөгөөд Өдөрлөгийн үеэр улсын бүртгэлийн үйлчилгээний чанар хүртээмж, албан хаагчдын харилцаа хандлагад үнэлэлт дүгнэлт өгөх зорилгоор үйлчилгээ авсан болон зөвлөгөө мэдээлэл авсан иргэдээс сэтгэл ханамжийн судалгааг QR код уншуулан цахимаар авахад 35 иргэн хамрагдсан байна. Өдөрлөгөөр нийт 263 иргэнд бүртгэлийн үйлчилгээг үзүүллээ. 2026.05.20-22 Өдрүүдэд Онцгой байдлын ерөнхий газраас Дундговь аймагт зохион байгуулж байгаа “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль”-ийн удирдах бүрэлдэхүүний танхимын сургалтад хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ё.Батбаяр хамрагдан бэлэн байдалд хонон ажиллаа. Мөн гамшгийн бэлэн байдлын үед иргэдийг бүртгэх, цугларах цэгт ажиллах, мэдээллээр хангах ажилд хэлтсийн төвийн 6, сумд албан хаагч ажиллаж байна.	
	Тухай бүр	15 сумдын ИТХурал, Засаг	5	10		ОНТөсөвөөс Өндөршил сумын сүлжээний 2 конвертирт гэмтэл гарч ажиллахгүй байсныг сумын	100

		урсгал зардал, хөрөнгө бусад эх үүсвэрээр	дарга, ЗДТГазартай хамтран ажилласан үйл ажиллагааны тоо			засаг даргаар шийдүүлэн шинээр авхуулан хэвийн ажиллагаанд орууллаа. Сумын ИТХ, сумын Засаг даргатай хамтран ажиллах хүрээнд орон нутгаас зохион явуулж байгаа олон нийтийн арга хэмжээнд төвийн болон сумдын албан хаагчид идэвхтэй оролцож ирлээ. Сайнцагаан сумын нийтийн хог цэвэрлэгээнд хэлтсийн 10 албан хаагч хуваарьт газрыг цэвэрлэлээ. Сайнцагаан сумын Засаг даргын 2026 оны 02 дүгээр сарын 06 ны өдрийн А/96 тоот захирамжийн хүрээнд сар бүрийн 2 дахь 7 хоногийн бямба гаригт зохион байгуулагддаг бүх нийтийн хог цэвэрлэгээнд хэлтсийн албан хаагчид хуваарьт газрыг 5 удаа цэвэрлэлээ. Баянжаргалан, Өндөршил сумын бүртгэгчид тус суманд гарсан малын гоц халдварт шүлхий өвчний пост болон, үлийн цагаан оготно устгах зэрэг орон нутгийн шинжтэй ажилд дайчлагдан ажиллаа.	
4.2.	Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх, мэдээ мэдээллийг хуулийн хугацаанд хүргүүлэх	-	Зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийн хувь	100	100	2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 1 албан шаардлага, 11,189.0 төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоогдсон бөгөөд ӨХБЗ-ийн гишүүд эс зөвшөөрч шүүхэд хандаж, ЗХАШ-ээс захиргааны хэрэг үүсгэсэн тул одоогоор маргаантай байна.	100
4.3	Бусад төрийн болон ТББайгууллагатай хуулийн хүрээнд хамтран ажиллах	Бусад эх үүсвэр	Хамтран ажилласан арга хэмжээний тоо	3	4	ШШГүйцэтгэх байгууллагын хүсэлтээр тус газар хоригдож байгаа Өвөрхангай аймгийн нэг иргэнийг биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл, мөн нэг иргэний гэрлэлтийн бүртгэлийг зөөврийн төхөөрөмжөөр бүртгэлээ. Монголын Хуульчдын холбооноос жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилготой хууль зүйн үнэгүй зөвлөгөө өгөх “Хуульчийн Про Боно өдөр-2025” өдөрлөгт хамтран оролцож 263 иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна. Малчдын оролцоо, хамтын ажиллагаа арга хэмжээнд төрийн 8 байгууллагатай хамтран “Иргэнд ээлтэй бүртгэл” аяны хүрээнд нээлттэй мэдээллийн	100

						өдөрлөгийг Гурван сайхан, Дэлгэрцогт сумдад зохион байгууллаа. "Иргэндээ ээлтэй бүртгэлийн үйлчилгээ"-ний аян хүрээнд 2026 оны 05 сарын 11, 14-ны өдөр Гурвансайхан, Дэлгэрцогт сумдад зохион байгуулагдсан малчны өдөрлөгт оролцож бүртгэлийн үйлчилгээг зөөврийн төхөөрөмжөөр газар дээр нь хүргэж ажиллалаа. Өдөрлөгийн "Та Монгол ээж" ТББ-тай хамтран төрийн албан хаагчдад зориулсан лекц сургалтад хэлтсийн албан хаагчид бүрэн хамрагдлаа.үеэр гадаад паспорт, иргэний үнэмлэх, тоон гарын үсэг олголтыг 35 иргэн, төрсний болон гэрлэсний нөхөн бүртгэл, засвар өөрчлөлтийг 28 иргэн, тараах материал, зөвлөмж мэдээллээр 58 иргэн нийт 121 иргэнд үйлчилгээ үзүүллээ.	
ЗОРИЛТ 5.БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ НЭГДСЭН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТААР ХАНГАНА							
5.1	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, төсвийн хөрөнгийг зүй зохистой зарцуулах, тайлагнах, байршуулах.		Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь	100	100	1-ээс 5-р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, үнэт цаасны тайлан, санхүүгийн тайланг УБЕГ-ын СҮХ-т хугацаанд нь хүргүүлсэн. 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайланг Сангийн яамны Е-тайланд 2-р сарын 25 -ны өдрийн дотор байршуулсан. 1-ээс 5-р сарын Нийгмийн даатгалын тайланг НДХ-т сар бүр /дараа сарын 5-ны дотор/ хугацаанд нь хүргүүлсэн. 2024 оны 4-р, 2025 оны 1-р улирлын татварын тайланг Татварын хэлтэст цахимаар гаргаж баталгаажуулан 100 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна. 2026 оны 05-р сарын 31-ны өдрийн байдлаар 522,941.4 мянган төгрөгийн санхүүжилт авч цалин хөлсний зардалд 324,322.2 мянга, унаа хоолны зардалд 60,166.1 мянга, НДШ-д 48,820.2 мянга, бичиг хэргийн зардалд 4,878.7 мянга, тээвэр шатахуунд 873.6 мянга, шуудан холбоонд 636.9 мянга, бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлийн зардалд 572.5 мянга, хог хаягдал зайлуулах зардалд 34.6 мянга, мэдээлэл технологийн үйлчилгээний зардалд 45.0 нийт 440,739.8 мянган төгрөг зарцуулж, 82,201.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй төсвийн гүйцэтгэл 84.3	100

						хувь байна. 2026 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар байр ашиглахтай холбоотой зардлын санхүүжилт дутуу орж ирсэн мөн 2026 оны “Орон нутгийн өөрийн өмчийн түрээсийн гэрээ” АЗДГ-аас батлагдаж ирээгүй байгаатай холбоотой 2026 оны 05-р сарын 31 өдрийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр байрны түрээсийн 4,588.5 мянган төгрөгийн өртэй байна. Уг өр төлбөрийг барагдуулахаар УБЕГ-ын СҮХ-т 06-р сарын төсвийн хуваарьт өөрчлөлт оруулж тусгахаар санал хүргүүлэн, жилийн эцсийн санхүүгийн тайлангаар өр төлбөргүй байхаар ажиллаж байна.	
5.2	Тогтоол шийдвэрийг хяналтад авч хэрэгжүүлэх		Байнгын хяналтад авч хэрэгжүүлсэн тогтоол шийдвэрийн тоо	5	6	Тайлант хугацаанд Иргэний улсын бүртгэлийн тасаг нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газраас ирүүлсэн нийт 8 удаагийн зөвлөмж, чиглэл, үүрэг даалгавар мөн АНСДИТХурлын нөхөн сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд 6 удаагийн үүрэг даалгавар нийт 14 үүрэг даалгаврыг хүлээн авч, тухай бүрд нь хэрэгжилтийг ханган тайланг илтгэх хуудсаар хугацаанд нь хүргүүлсэн. 2026 оны 05 дүгээр сарын 31-ны байдлаар хуулийн зүйл заалт болон архив албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу А тушаал 5, Б тушаал 8 боловсруулан нийт 13 тушаал шийдвэр гаргасан байна.	100
5.3	УБЕГазраас ирүүлсэн үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллах	-	Үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь	100	100	ХЗДХС-ын 01-дугаар албан даалгавар, УБЕГ-ын даргын 5 үүрэг даалгавар, сар бүрийн хугацаат мэдээ, тайлан, албан бичгээр ирүүлж байгаа чиглэл, зөвлөмж, АЗДТГ-аас өгөгдсөн албан үүрэг даалгаврын тус хэлтэст хамааралтай заалтын хэрэгжилтийг гарган заасан хугацаанд хүргүүлж ажиллаа. “Улсын бүртгэлийн байгууллагын сахилга, дэг журам, хариуцлагыг сайжруулах, үйлчилгээний чанар стандарт, бүтээмжийг дээшлүүлэх арга хэмжээний тухай” Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2026 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 1/29 дүгээр албан даалгаврыг орон нутагт хэрэгжүүлэх ажлын хүрээнд	100

						Улсын бүртгэлийн хэлтсийн Захиргааны ахлах мэргэжилтэн, Хяналтын улсын байцаагч, Иргэний бүртгэлийн тасаг, Эд хөрөнгө, хуулийн этгээдийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн ахлахууд сумдын бүртгэгч нарын дунд онлайн хурлыг 2026 оны 02 дүгээр 02-ны өдөр зохион байгууллаа. -Тайлант хугацаанд Иргэний улсын бүртгэлийн тасаг нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газраас ирүүлсэн нийт 8 удаагийн зөвлөмж, чиглэл, үүрэг даалгавар мөн АНСДИТХурлын нөхөн сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд 6 удаагийн үүрэг даалгавар нийт 14 үүрэг даалгаврыг хүлээн авч, тухай бүрд нь хэрэгжилтийг ханган тайланг илтгэх хуудсаар хугацаанд нь хүргүүлсэн.	
5.4	Үнэт цаасны зарцуулалтад хяналт тавьж бүртгэгчийн буруутай үйлдлээс хүчингүй болголтыг бууруулах	-	Хүчингүй болгосон үнэт цаасны тоо	130	60	2026 оны эхний хагас жилийн байдлаар 61 Үнэт цаас хүчингүй болсноос 53 нь Улсын бүртгэгчийн алдаанаас, 8 нь техникийн алдаанаас хүчингүй болсон. Эхний хагас жилийн байдлаар улсын бүртгэгчдээс иргэний улсын бүртгэлийн маягт гэрчилгээг техникийн алдаанаас 7, бүртгэгчдийн алдаанаас 48 ш нийт 55 ш үнэт цаасыг хүчингүй болгосон байна. Үүнд: Төрсний гэрчилгээ 18, гэрлэлтийн гэрчилгээ 0, нас барсны гэрчилгээ 12, үндсэн бүртгэл 12, ИУБ-31 маягт 11, шилжилт хөдөлгөөний 2 үнэт цаас байна. Хүчингүй болсон үнэт цаасны тоо өмнөх оны хагас жилээс 38%-р өссөн үзүүлэлттэй байна. Нийт хүчингүй болсон үнэт цаасны 50.8%-г буюу 31 ширхгийг Сайнцагаан сумын бүртгэгч хүчингүй болгосон байна. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтөлж байгаа сумын 3, хэлтсийн 3 бүртгэгч газар өмчлөх эрхийн 392, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн 207 нийт 599 үнэт цаас зарцуулснаас 3 бүртгэгч газар өмчлөх эрхийн 4 гэрчилгээг хүчингүй болгосон байна.	100
5.5	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах		Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хувь	100	100	2026 оны 1,2,3,4,5-р сард нийт 73 мэдээллийг 100 хувь бүрэн байршуулсан. Үүнээс мэдээлээгүй 0, хугацаа хоцорсон төлөвтэй 0, хугацаандаа байршуулсан 73, 100 хувийн гүйцэтгэлтэй байна. 1-р	100

						улирлын шилэн дансны тайланг 2026 оны 4 сарын 2-ны өдөр хугацаанд нь илгээсэн.	
			Тайлагнаж, байршуулсан мэдээллийн тоо	170	170	206 онд нийт 170 мэдээлэл байршуулахаас 6-р сарын 1-ны өдрийн байдлаар 73 мэдээлэл байршуулахаас 73 мэдээллийг бүрэн байршуулсан. Хэрэгжилт 100 хувьтай байна.	100
ЗОРИЛТ 6. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ХӨТӨЛБӨР, ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ САЛБАР ДУНДЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ДЭД ЗӨВЛӨЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛНЭ							
6.1	Улсын бүртгэлийн хэлтсийн 2026 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж хэрэгжилтийг хангах.		Авлигын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	Хэлтсийн авлигаас урьдчилан сэргийлэх, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор 2026 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2026 оны 1 дүгээр сарын 08-ны өдөр боловсруулан гаргасан. Төлөвлөгөөнд авлигын эрсдэлийг бууруулах, соён гэгээрүүлэх чиглэлээр нийт 6 үндсэн заалт бүхий хэрэгжүүлэх арга хэмжээг тусган ажиллаж байна. Хэлтсийн хэмжээнд авлигад өртөж болзошгүй эмзэг цэгүүд буюу бүртгэгч нарын ачаалал, шийдвэр гаргах үйл явцыг тодорхойлж, эрсдэлийн зураглал гаргах Авлигын эрсдэлийн үнэлгээ-г хийсэн бөгөөд энэ ажлын хүрээнд нийт үйл ажиллагааны 100% эрсдэлийг үнэлж, тайлан, дүгнэлт гаргахаар Хяналтын улсын байцаагч, Тасгийн дарга нар хариуцан ажиллаж байна. Мөн жил бүрийн 2 дугаар сард багтаан Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-ийг хугацаанд нь үнэн зөв мэдүүлэх, зөвлөгөө өгөх, хяналт тавих ажлыг зохион байгуулж, зөрчилгүй мэдүүлэлтийг гаргаж ажиллалаа. Захиргааны ахлах мэргэжилтэн, хяналтын улсын байцаагч бүх албан хаагчдыг хамруулан орон нутгийн АТГ болон хууль хяналтын байгууллагуудтай хамтарсан "Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх" сэдэвт кейс дээр суурилсан ёс зүй, авлигын эсрэг сургалтыг цахим болон танхим хэлбэрээр зохион байгуулж, хэлтсийн нийт албан хаагчдыг хамруулахаар төлөвлөсөн бөгөөд 6 дугаар сард хийгдэнэ. Сумдад үзүүлж буй улсын бүртгэлийн үйлчилгээнд	100

						дотоод хяналт шалгалт хийхдээ авлигаас ангид байх зааварчилгааг газар дээр нь өгөх Цахим бүртгэлийн хяналт-ыг Хяналтын улсын байцаагч хариуцан гүйцэтгэж, бүх сумдын бүртгэгч нарыг нэгдсэн зааварчилгаа, зөвлөмжөөр хангаж байна. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, үйлчилгээний шимтгэл, хураамжийг ил тод байршуулах чиглэлээр улсын бүртгэгч, албан хаагчид соён гэгээрүүлэх нөлөөллийн ажлыг зохион байгуулах, гарын авлага, постер хийх, цахим хэвлэл ашиглан олон нийтэд сурталчлах ажлыг байнга хийж байна. эрсдэлийн үнэлгээ Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл: Үл хөдлөх эд хөрөнгийг анх удаа бүртгэх, шинээр баригдсан орон сууц болон барьцаат зээлийн гэрээг бүртгэх үйл явц нь "Маш өндөр" эрсдэлтэй үйлдэлд тооцогдож байна. Үүнийг шийдвэрлэх хяналтын механизм нь Хяналтын улсын байцаагч болон тасгийн даргын давхар цохолт, хяналтаар баталгаажих юм. Хуулийн этгээдийн бүртгэл: Компанийн хувьцаа эзэмшигчийг өөрчлөх, тамганы хяналтын дугаар олгох, татан буулгах үйл ажиллагаа нь "Өндөр" эрсдэлтэй тул хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, гарын үсгийг заавал биечлэн эсвэл цахим гарын үсгээр баталгаажуулж, Тасгийн дарга болон хяналтын улсын байцаагч давхар хяналт тавина. Сумдын улсын бүртгэгч нар: Алслагдсан сумдад хяналт сул байгааг ашиглан бичиг баримт дутуу бүрдүүлэх, иргэдээс илүү нотлох баримт шаардах нь "Өндөр" эрсдэлтэйд тооцогдсон тул сумын бүртгэгчийн хийсэн бүртгэл бүрийг аймгийн системээр дамжуулан тасгийн дарга, хяналтын улсын байцаагч нар шууд хянадаг. Иргэний улсын бүртгэл: Гадаад паспортын бүртгэл хийх үйл явц нь "Дунд" түвшний эрсдэлтэйд тооцогддог бөгөөд үүнд тасгийн дарга баталгаажуулалтыг тогтмол хянаж ажиллах. Сургалт:	
--	--	--	--	--	--	--	--

						Аймгийн Засаг даргын тамгын газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Авлигатай тэмцэх газартай хамтран аймгийн удирдах болон эрх бүхий албан тушаалтнуудад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгууллаа. Сургалтаар Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар С.Янжиндулам “Авлигын ойлголт, хор хөнөөл түүнээс урьдчилан сэргийлэх арга зам” Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар Б.Баяртөгс “Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар А.Тунамал-Эрдэнэ “Авлигын гэмт хэрэг” зэрэг сэдвүүдээр албан хаагчдад мэдээлэл хүргэв. Уг сургалтад хэлтсийн 12 албан хаагч хамрагдлаа.	
6.2	Үйлчилгээний зааланд хөгжлийн бэрхшээлтэй иргэн үйлчлэх тэмдэг, тэмдэглэгээнд сонсголын бэрхшээлтэй иргэн гэх таних тэмдэг болон “Тусламжийн хонх”-ыг байршуулах.		Таних тэмдгийг нэмж байршуулсан үйлчилгээний заалны тоо	3	6	2026.03.03 Улсын бүртгэлийн үйлчилгээний зааланд, Хулд сумын ЗДТГ-ын үүдэнд тус тус “Тусламжийн хонх”-ыг байршуулсан бөгөөд хонх дуугарах тухайн үед чөлөөтэй байгаа бүртгэгч тосон очиж шаардлагатай мэдээллийг өгч, үйлчилгээ авах бүртгэгч дээр нь хүргэж өгөн ажиллаж байна. Мөн бүх сумдын бүртгэгчдийн өрөөний үүдэнд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчлэх тэмдэг, тэмдэглэгээнд сонсголын бэрхшээлтэй иргэн гэх таних тэмдэг байршуулсан байна. Тусламжийн хонхоор 8 иргэнд тосон очиж Тоон гарын үсэг бүртгэл хийж мэдээлэл өгсөн.	100
6.3	Хөгжлийн бэрхшээлтэй болон тусгай хэрэгцээт иргэдэд зөөврийн тоног төхөөрөмжөөр явуулын үйлчилгээ үзүүлэх, төлөвлөгөө гаргаж		Дэд төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	2026.01.28 Өөрийн биеэр үйлчилгээ авах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд явуулын төхөөрөмж ашиглан улсын бүртгэлийн үйлчилгээг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 1 иргэн Сайнцагаан сумын 5-р багын хөгжлийн бэрхшээлтэй 2 иргэний гэрээр очиж биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлийн үйлчилгээ үзүүлж ажиллалаа. Сайхан-Овоо сумын улсын бүртгэгч Ц.Отгонсугир нь 2026.03.12-2026.12.13“ Хөгжлийн бэрхшээлтэй болон зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн ажлын” хүрээнд 4 жи	100

	хэрэгжилтийг хангах.					төхөөрөмж ашиглан зорилтод бүлгийн болон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй 6 иргэнд Улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээлэл хүргэж үйлчилгээ үзүүлж ажилласан. Мөн Дэлгэрцогт сумын улсын бүртгэгч Г.Намжим 2026.03.18нд зөөврийн 4жи төхөөрөмжөөр хөгжлийн бэрхшээлтэй болон гэрээс гарч үйлчилгээ авах боломжгүй асаргаанд байдаг 5 иргэнд гэрээр очиж үйлчилгээ үзүүлсэн 2026.04.09 Өөрийн биеэр ирж үйлчилгээ авах боломжгүй иргэнд 4ж төхөөрөмж ашиглан ЭХЭУБ Н.Уугантуяа гэрээр очиж Төрөөс үнэгүй хувьчилсан 0.7 газрын бүртгэл үйлчилгээ үзүүлж ажилласан	
6.4	Жендэрийн эрх тэгш байдлын дэд төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах.		Дэд төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	Жендэрийн эрх тэгш байдлын төлөвлөгөөг боловсруулан хэлтсийн даргаар батлуулан ажиллаж байна. Жендэрийн үндэсний хорооноос жил бүр зохион байгуулдаг “Харилцан хүндэтгэе” аяны хүрээнд “Хайрлая, хандлагаа өөрчилъе, хамтдаа үлгэрлэе” уриан дор Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, монгол цэргийн өдрийн хүрээнд зохион байгуулах “Харилцан хүндэтгэе” үндэсний хэмжээний аяны хүрээнд зохион байгуулсан ажлын тайланг УБЕГ-т хугацаанд нь хүргүүлсэн. Аймгийн Засаг даргын Тамгын газар, Жендэрийн үндэсний хороотой хамтран зохион байгуулсан “Би Монгол эр хүн” аймгийн эрэгтэйчүүдийн чуулганд хэлтсийн 2 эрэгтэй албан хаагч оролцов.	100
6.5	Гэмт хэрэг, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийн хүрээнд дэд төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг хангах.		Дэд төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	Байгууллагын Гэмт хэрэг, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийн хүрээнд дэд төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг ханган ажиллаж байна Дундговь аймгийн Шүүх шинжилгээний криминалистикийн шинжээч А.Энхжин “ Баримт бичгийн шинжилгээ” сэдвээр танхимын сургалтыг зохион байгуулан 9 албан хаагч хамрагдлаа. Хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдал, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, болон Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх онлайн 1, танхимын 1 сургалт,	100

						Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Салбар зөвлөлөөс зохион байгуулсан танхимын 1 сургалт болон онлайн сургалтуудад хэлтсийн бүрэлдэхүүн 100 хувь хамрагдлаа.	
6.6	Гэр бүл, хүүхдийн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангах.		Дэд төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	2026 оны УБЕГ-ийн хүүхдийн эрхийг хамгаалах хэлтсийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Дундговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь сар бүрийн эхний долоо хоногийн баасан гаригийг “Гэр бүлийн өдөр” болгон арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж эхэллээ. Дундговь аймгийн Засаг даргын 2026 оны 03 дугаар сарын 12 ний А/152 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд “ Гэр бүлийн өдөр”-ийн ээлжит арга хэмжээг “ МЭРГЭЖИЛ СОНГОЛТ “ сэдвээр амжилттай зохион байгууллаа. Тус захирамжийн сар бүрийн эхний долоо хоногийн баасан гаригийг “ГЭР БҮЛИЙН ӨДӨР” болгон тэмдэглэж ажилтан албан хаагчдын гэр бүлийн оролцоог дэмжсэн олон талт арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж байна. Арга хэмжээний үеэр сурагчдад байгууллагын үйл ажиллагаа хэлтсийн чиг үүрэг ,төрийн албаны ажлын онцлогийг танилцуулж ирээдүйн мэргэжлээ зөв сонгоход анхаарах асуудлын талаар мэдээлэл өгч ажлын байртай танилцууллаа. Түүнчлэн хувь хүний сонирхол, ур чадвар ,үнэт зүйлд нийцсэн мэргэжил сонголт хийхийн ач холбогдлыг онцолж харилцан ярилцлага өрнүүлсэн нь оролцогчдод бодит ойлголт чиг баримжаа олгосон үр дүнтэй үйл ажиллагаа боллоо. Мөн эх үрсийн баярыг тохиолдуулан байгууллагын гэр бүлийн зөвлөлөөс ажилтнуудын хүүхдүүдийг хүлээн авч, нөхөрсөг уулзалт арга хэмжээг зохион байгуулан, баярын бэлэг гардууллаа.	100
6.7	Хүний эрхийн дэд төлөвлөгөөний хэрэгжилт		Дэд төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	УБЕГазрын хүний эрхийг хамгаалахтай холбоотой дээд шатны байгууллагуудын баталсан төлөвлөгөөг үндэслэн хэлтсийн хүний эрхийг хангах 9 арга хэмжээ бүхий хэлтсийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг	100

						хангаж ажиллалаа. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн нийтлэг зорилго нь иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, алагчлалгүй үйлчлэх үүднээс мэдээллийн ил тод байдлыг хангах, зөвлөгөө тусламжийг бүрэн үзүүлж хэвших, иргэдийн мэдэх эрхийг хангах авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх зорилгоор улсын бүртгэгчдэд сургалт зохион байгуулж дараах зарчмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг зөвлөлөө. -Мэдээллийн ил тод самбар: Бүртгэлийн үйлчилгээ авахад бүрдүүлэх материалын талаар тодорхой ойлгомжтой цахим болон мэдээллийн самбарт байршуулах. -Бүрэн зөвлөгөө өгөх соёл: Иргэнд “ Болно, болохгүй” гэж хэлэхээс өмнө яавал болох вэ? гэдэг гарц гаргалгааг хуулийн хүрээнд тайлбарлан өгч, тусламж үзүүлж хэвших. -Урьдчилан сэргийлэх мэдээлэл: Гадаад паспорт, тоон гарын үсэг, иргэний үнэмлэх шинээр болон хугацаа сунгах, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн ач холбогдлын талаар иргэдэд мэдээллийг тогтмол хүргэх. -цаг баримтлал: Үйлчилгээний хугацааг баримтлахаас гадна иргэний цагийг хүндэтгэж заавал хуулийн хугацааг хүлээх биш түргэн шуурхай, иргэнд ээлтэй үйлчилгээг хүргэж ажиллах. -мэргэжлийн туслалцаа: Бичиг баримтын бүрдэл дутуу тохиолдолд иргэнийг буцаах биш хаанаас ямар мэдээллийг авч болох талаар чиглүүлж өгөх зэргээр хүний эрхийг хангаж ажиллахыг үүрэг болголоо.	
ЗОРИЛТ 7.ЧАДАХУЙН ЗАРЧИМД СУУРИЛСАН ХҮНИЙ НӨӨЦИЙГ БҮРДҮҮЛЖ, АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАНА.							
7.1.	Байгууллагын 2026 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх	-	Сургалтын төлөвлөгөөний биелэлтийн хувь	100	100	УБЕГ-ын Албан хаагчдын ур чадварыг хөгжүүлэх болон ажлын байрны сургалтын цаг сэдвийн нэгдсэн төлөвлөгөө, мөн нийт албан хаагчдаас ирүүлсэн саналаас тусган 16 арга хэмжээ бүхий албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх 2026 оны сургалтын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэн ажиллаж	100

						байна . Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнээс тасарсан болон дутуу хэрэгжсэн заалт байхгүй. ХАБЭА-н сарын аяны хүрээнд байгууллагын ажилтнууд болон сумдын улсын бүртгэлийн мэргэжилтнүүдийг цахим,танхимаар ХАБЭА-н сургалтад хамрууллаа. ХАБЭА-н хууль,түүнийг дагаж мөрдөх дүрэм журам, ААНБ-ын ХАБЭА-н бодлого, ҮО,ХХ судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын үйл ажиллагаа, Эрсдэлийн үнэлгээ сэдвүүдээр сургалт хийгдлээ. Уг сургалтыг аймгийн ҮЭ-ийн Холбооны дарга, БАЗ, ХАБЭА-н сургагч багш Б. Мөнхчулуун зохион байгууллаа. Энэ үеэр байгууллагын ХАБЭА- Эрсдэлийн үнэлгээ хийж албан хаагчдад аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч баталгаажууллаа. Цагаан сарын баяр амралтын үеийн аюулгүй байдлын зааварчилгаа, албан томилолтоор явах үед тээврийн хэрэгслийн жолооч нарт давхар аюулгүй ажиллагааны зааварчилгаа,мөн албан тасалгааны ажилтны аюулгүй ажиллагааны зааварчилгааг 7 хоног бүрийн 1 дэхь өдөр албан хаагчдад өгч тус тус баталгаажуулан ажиллаж байна.	
7.2.	Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Улсын болон ОНТөсөв, бусад дэмжлэг	Нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	-УБЕГ –аас албан хаагчдын нийгмийн баталгааг шийдвэрлэх зорилгоор орон сууцжуулах хөтөлбөрт 2 албан хаагч хамрагдаад байна. -Байгууллагын өндөр настан Ж.Мижиддорж нь Сайнцагаан суманд өрхийн үйлдвэрлэл болох төмс хүнсний ногоо тариалах үйл ажиллагаа эрхлэн явуулдаг бөгөөд энэ үйл ажиллагаандаа зориулж 5 сарын тэтгэвэртэй тэнцэх хэмжээний санхүүгийн дэмжлэг буюу 5000,000 хүссэн өргөдөл өгсөн бөгөөд 2026-05-04 ны өдрийн №01 дугаар Ахмадын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж уг дэмжлэгийн 100 хувь олголоо -Дундговь аймаг нь 2026 оныг “Боловсрол, эрүүл мэндийг дэмжих” жил, Эрүүл мэндийн салбараас “Хүн амын эрүүл мэндийг дэмжихэд албан байгууллага, аж	100

						ахуйн нэгж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх” жил болгон зарласан. 2026.04.07 “Эрүүл мэндийн өдөрлөг” үйл ажиллагааны хүрээнд аймгийн төвийн эрүүл мэндийн байгууллагууд биеийн найрлага тодорхойлох аппаратын оношилгоо, дүгнэлт, зөвлөмж, цусанд сахар, холестерин, элэгний В, С вирус тодорхойлох шинжилгээ, Д аминдэм болон ясны сийрэгжилт тодорхойлох шинжилгээ, зүрх судасны өвчний эрсдэлийн үнэлгээ, эмчийн үзлэг, зөвлөгөө өгч ажилсан бөгөөд тус арга хэмжээнд хэлтсийн 14 албан хаагч бүрэн хамрагдаж үзлэг оношилгоо хийлгэж зөвлөгөө авлаа. 2026.05.01 -Эрүүл мэндийг дэмжих чиглэлээр амьдралын зөв дадал хэвшил төлөвшүүлэх, эрүүл зөв хооллолт, эрүүл хүнсний талаар Архи, тамхи зэрэг хорт зуршлаас татгалзах нөлөөллийн арга зэрэг сургалтыг Засаг даргын тамгын газрын соёмбо тахимд бүх албан хаагчдыг хамруулж 5-р сарын 01 өдөр зохион байгууллаа. Сургалтаар: Амьдралын зөв дадал хэвшил, эрүүл зөв хооллолт, өөрт тохирсон идэвхтэй дасгал хөдөлгөөн хийх,хорт зуршлаас татгалдах, хувийн ариун цэвэр сахих, хуванцар савны хэрэглээг халах, архи тамхины хэрэглээг багасгах зэрэг зөвлөмж сургалт үр дүнтэй боллоо.	
7.3	Төрийн албан хаагчийн ёс зүй, манлайллыг сайжруулах төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг хангах.		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	100	2026 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр Ёс зүйн зөвлөлийн ажиллах төлөвлөгөөг боловсруулан гаргалаа. Төлөвлөгөө нь байгууллагын соёл, хариуцлагатай байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн нийт 7 үндсэн арга хэмжээг тусгасан бөгөөд тэдгээрийг дараах чиглэлүүдэд хуваан хэрэгжүүлэхээр тусгасан. сургалт ба соён гэгээрүүлэх ажил: Ёс зүйн тухай хууль тогтоомж, журмыг сурталчлах сургалтыг зохион байгуулж, нийт албан хаагчдын 95%-аас дээш хувийг хамруулахаар тусгасан. Мөн сумдад тохиолддог түгээмэл 5-аас доошгүй эрсдэлт кейсийг (танил тал харах, дараалал дайрах г.м) хэлэлцэх уулзалтыг зохион байгуулж, шийдвэрлэх арга барилд суралцах.	100

						Албан хаагчдаас ёс зүйн соёл, байгууллагын уур амьсгалын судалгааг авч, ажилчдын сэтгэл ханамжийн индексийг 85%-аас дээш түвшинд хүргэхээр төлөвлөлөө. Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг "Нээлттэй хаалганы өдөр"-өөр дамжуулан хугацаанд нь 100% бүрэн шийдвэрлэхийг зорино. Үүний зэрэгцээ ашиг сонирхлын зөрчлөөс 100% урьдчилан сэргийлэх зөвлөмжүүдийг хүргүүлж ажиллана. Сахилгын зөрчилгүй хамт олон бүрдүүлэх зорилгоор "Ёс зүйтэй бүртгэгч" сар бүрийн уралдааныг зарлаж, шагнаж урамшуулахаар тусгасан байна. Сургалт: 2026.01.22 ны өдөр "Ёс зүйг дээдэлсэн байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд төрийн албан хаагчийн оролцоо" сэдэвт сургалт уулзалтыг УБХ-ийн дарга, сургагч багш Ж.Өлзийжаргал албан хаагчдад зохион байгууллаа. Уг сургалтад тахимаар 14, цахимаар 10 сумын бүртгэгч хамрагдлаа. Ёс зүйн, харилцаа, хандлага сэдвээр албан хаагчид дунд видео, контент хийж, байгууллагын цахим хуудсаар түгээж ажиллаа. Улсын бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ё.Батбаярын баталсан удирдамжийн дагуу "Хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний стандарт болон ёс зүй, харилцааны ур чадвар" сэдэвт сургалтыг 2026 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр 16:00-18:00 цагийн хооронд амжилттай зохион байгууллаа. Тус сургалтад Улсын бүртгэлийн хэлтсийн нийт албан хаагчид болон сумдын улсын бүртгэгч нар цахимаар бүрэн хамрагдсан байна. Сургалтын бэлтгэл ажил, оролцогчдын ирцийг улсын бүртгэгч Н.Уугантуяа хариуцан зохион байгууллаа. Сургалтаар улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчдын сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэх, хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг хангах, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, стандартыг сайжруулахад чиглэсэн дараах хоёр үндсэн сэдвийг хэлэлцлээ.	
--	--	--	--	--	--	--	--

							-Хөдөлмөрийн дотоод журам: УБЕГ-ын хөдөлмөрийн дотоод журмын танилцуулга, анхаарах асуудлуудын талаар Сайхан-Овоо сумын улсын бүртгэгч Ц.Отгонсугир мэдээлэл хийж, оролцогчидтой асуулт, хариулт өрнүүлэв. -Үйлчилгээний соёл ба ёс зүй: Төрийн үйлчилгээний стандарт, ёс зүйн хэм хэмжээ, иргэдтэй харилцах ур чадварын талаар Цагаандэлгэр сумын улсын бүртгэгч З.Отгонмаа илтгэл тавьж, бодит жишээ (кейс)-нд тулгуурласан нээлттэй хэлэлцүүлэг, туршлага солилцох уулзалтыг өрнүүллээ. Сургалтын төгсгөлд хэлтсийн удирдлагын зүгээс үр дүнг нэгтгэн дүгнэж, цаашид иргэдтэй ёс зүйтэй, зэрэгцээ харилцааг хэвшүүлж ажиллахыг нийт албан хаагчдад үүрэг болгов. -Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2026 оны 3 дугаар сарын 18-ны өдөр "Ёс зүй, сахилга хариуцлагын 2025 оны үнэлгээ"-ний дүнтэй холбогдуулан аймаг, дүүргийн хэлтсийн дарга нарт хандан албан ёсны чиглэл ирүүлсэн. Уг чиглэлээр байгууллагын авсан 75%-ийн үнэлгээг ахиулахын тулд албан хаагчийн ёс зүйн зөрчлийн эрсдэлийг жил бүр үнэлж, багц цагийн сургалтыг тогтмол зохион байгуулахыг үүрэг болгосон байна. Мөн удирдах албан тушаалтнуудад инновац шингээсэн ёс зүйн орчин бүрдүүлэх, ментор болон коучингийн арга хэмжээ авч, үйл ажиллагаагаа олон нийтэд тайлагнан сэтгэл ханамжийн судалгаа авахыг даалгалаа. Үүнээс гадна соён гэгээрүүлэх ажлын төрлийг төсвийн хамт төлөвлөгөөнд тусгаж, танин мэдэхүйн олон талт үйл ажиллагааг өргөжүүлэх шаардлагатай байгааг мөн Ёс зүйн дэд хорооны 2026 оны ажлын төлөвлөгөө болон өмнө хүргүүлсэн "Ёс зүйн хариуцлагыг сайжруулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай" зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулж, үр дүнг тооцож ажиллахыг үүрэг болгосон бөгөөд албан хаагчдад чиглэлийг хүргэсэн.	
7.4	Монгол цахим бичгийн бичвэрт албан хаагчдыг	-	Цахим бичвэрээр бичих чадвартай болсон албан	2	5	Аймгийн хэлний бодлогын салбар зөвлөлөөс   "Үндэсний бичиг үсгийн баяр"-ыг угтан зохион байгуулж буй арга хэмжээнд үнэт цаас бараа	100	

	сургах		хаагчийн тоо				материал хариуцсан ажилтан Ц.Уртнасан амжилттай оролцсон. Үндэсний цахим бичвэрээр тогтмол албан бичиг хөтөлж буй 5 албан хаагч байна. Хэлтсийн өрөө тасалгаа 8, мэдээллийн самбар 2ш , танилцуулга, хувийн хэрэг 24ш-ийг үндэсний бичгээр шинэчлэн боловсруулсан байна.	
7.5	“Нэг албан хаагч-Нэг санаачилга” арга хэмжээг хэрэгжүүлэх	Байгуулл ага, орон нутгийн төсөв, бусад эх үүсвэр	Санаачилж хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	15	25		Хулд сумын улсын бүртгэгч Р.Сүндэръяа санаачлан ЗДТГ-н Эцэг эхийн зөвлөлтэй хамтран "ХОС ЗҮРХ" гэр бүлийн өдөрлөгийг зохион байгууллаа. Уг арга хэмжээнд 4 хосын гэрлэлтийг баталж , гэр бүлийн үнэ цэнэ, хариуцлага, хамтын оролцоог эрхэмлэн аз жаргалтай, тогтвортой гэр бүлийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээллийг хүргэж, улсын бүртгэлийн үйлчилгээтэй холбоотой сонирхсон асуултад хариулан зөвлөгөө өгч хамтран ажилласан байна	100
7.6	Монгол хэлний тухай хууль, Монгол Улсын засгийн газрын 2020 оны 96-р тогтоолын хэрэгжилтийг ханган албан хэргийг кирилл болон үндэсний хос бичгээр хөтөлж эхлэх	-	Кирилл болон үндэсний хос бичгээр хөтөлсөн хувь	-	100		Архив албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу А, Б 13 тушаалыг үндэсний бичгээр хөрвүүлэн ажилласан. Албан хаагчдад үндэсний бичгээр хөрвүүлэх заавар бичлэг хэлтсийн группэд байршуулсан мөн ERP системийн файлын санд үндэсний бичгээр шивэх бэлэн загвар байршуулж ажилласан. Цахим монгол бичгээр боловсруулж илгээсэн 220 явсан албан бичиг байна.	100